

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**ШИНЭ, ШИНЭХЭН ҮЕИЙН ХЯТАД БА ТҮҮНИЙ
ХӨРШҮҮД. М., 1982***

Академич С. Л. Тихвинскийн редакторласан энэхүү өгүүллүүдийн эмхтгэлд XVII — XX зууны үеийн Хятад, түүний хөрш орнуудын хоорондын харилцааг түүхэн тодорхой материал дээр авч үзжээ. Түүний бичсэн өмнөх өгүүлэлд Хятадын эзэн хаадын уламжлалт хятад төвийн номнолыг залгамжлан авсан манж Чин гүрний эрх баригчид болон тэдний дараах хятадын милитаристуудын их гүрний дээрэнгүй бодлогыг Хятадын дэвшилт, ардчилсан хүчний төлөөлөгчид тухайлбал Тань Сытун, Сун Ятсен, Лу Синь, түүнчлэн ялангуяа Ли Дачжао, Цюй Цюбо нарын зэрэг коммунистууд эрс шүүмжилж байсныг харуулжээ. Тэдний дотор Ли Дачжао Монголын биеэ даасан байдал, түүний Хятадаас бүрэн тусгаар тогтносон байдлын төлөө зогсож хятадын үндсэрхэг үзэлтнүүдийн эзлэн түрэмгийлэх санаархлыг шүүмжилж байв.

Дэлхий дахины түүх, хятад-оросын харилцаа, хятад-хөрш зэргэлдээ орнуудын харилцааны талаар 70-аад онд Хятадын Төв хэвлэлд Хятадын түүхчдийн бичсэн хэд хэдэн «удирдамжийн чанартай өгүүллийг С. Л. Тихвинский задлан шинжилж тэдгээрт тусгагдсан түүх зүйн зарчимд харш, Зөвлөлтийн эсрэг, хөрш орнуудын газар нутагт тавих өнгөлзлөгөө «үндэстэй» болгох гэсэн санаа бүхий оролдлогыг эрс няцаажээ.

1976 оны 10-р сард Бээжингийн удирдлагаас «дөрвийн бүлгийг» зайлуулсны дараа түүхийн ухааны салбарт зарим хэт явцгүй зүйлийг хянан засварлаж эхэлсэн боловч хөрш орнууд, ялангуяа ЗСБНХУ, БНМАУ, БНСВУ, БНАЛАУ болон Хятадын хорондын харилцааны түүхийг мушгин завхруулсан түүхийн судалгааны» тоо «соёлын хувьсгалын» жилүүдээс ч их болсныг зохиогч тодорхой баримтаар нотлон үзүүлжээ.

В. С. Мясников, Н. В. Шепелева нар XVII зуунаас XX зууны эх хүртэлх Чин гүрэн-Оросын харилцааны талаар бичихдээ 1894 он хүртлэх 300 орчим жил нь худалдаа хийх газар нутаг-хилийн асуудлыг зохицуулах зэрэгтэй холбогдон хоёр орны хооронд хэлхээ холбоо тогтоон хөгжүүлэх үе байсан бөгөөд энэ үед Оросын бодлого Англи, Франц зэрэг бусад их гүрний Хятадын талаарх бодлогоос үлэмж ялгаатай байсныг харуулжээ. 1894 оноос хойш урьдахаас чанарын хувьд ялгаатай шинэ үе эхэлснийг зохиогчид тэмдэглэжээ. М. С. Капица Зөвлөлт-Хятадын харилцааны тухай өгүүлэлдээ Октябрийн хувьсгалын ялалтаар хоёр орны харилцаанд цоо шинэ үе эхэлснийг дурдаад ЗХУ-ын зарчимч, тууштай энх тайванч гадаад бодлогыг тод томруун харуулжээ.

В. С. Мясников, Н. В. Шепелева нар өөр нэг өгүүлэлдээ XVII-XX зууны үеийн хятад-Монголын харилцааг тусгажээ. Энэ өгүүллийн та-

* Китай и соседи в новое и новейшее время. М., 1982.

лаар юуны өмнө хоёр зүйл тэмдэглэж болох байна. Нэгд, тус өгүүлэл 70-аад оны И. С. Ермаченко, Ш. Б. Чимитдоржиев, Г. С. Горохова зэрэг Зөвлөлтийн түүхчдийн туурвисан бүтээлүүдийн үнэлэлт дүгнэлтийг нэгтгэн тусгажээ. Хоёрт, 1917 он хүртэлх хятад-монголын харилцааг авч үзэхдээ XVII зууны сүүлчээс Алс Дорнодын олон улсын харилцаанд чухал хүчин зүйл болж гарч ирсэн Оросын бодлоготой нягт уялдуулан задлан шинжилжээ. Хятадын уламжлалт гадаад бодлогын гол зорилго нь өөрийн эргэн тойронд хязгаарлагдмал автономит эрхтэй хараат буюу эзэмшил орнуудыг бий болгоход оршиж байсныг зохиогчид дурьдаад Цин гүрэн айлган сүрдүүлэх, илбэн тохиуулах аргыг хослон хэрэглэж Халхыг мэдэлдээ оруулснаар Монголыг тийм завсрын бүс болгон хувиргах анхны алхам хийсэн гэжээ. Гэвч XVII зууны I хагасаас хүчирхэгжиж ирсэн Ойрадаас баруун ба зүүн бүх монголчуудыг нэгтгэхийн төлөө хийсэн тэмцэл нь Чин улсын эзэн хаадын эсэргүүцэлтэй тулгарчээ. Нөгөө талаас тэр үед сайжирч ирсэн Орос-Ойрадын харилцаа Чин улсын эзлэн түрэмгийлэх төлөвлөгөөнд ноцтой аюул учруулж болзошгүй байсан тул Хятадын эзэн хаад орос-монголын харилцааг эвдэх санаархалдаа Халхын эрх баригчдад чухал үүрэг оноож байсныг зохиогчид тэмдэглэжээ. Иймд Зүүнгартай өрсөлдөхийн тулд XVIII зууны эхний хагаст Халх дахь байр сууриа бэхжүүлэх бодлогыг Чин улсын засаг захиргаа явуулжээ. Мөн орос-зүүнгарын хэлэлцээр тасарсан буюу 1745 онд Ойрадын Галданцэрэн нас нөгчсөний дараа тэнд хаан ширээний төлөө тэмцэл өрнөсөн нь Зүүнгарын хэрэгт идэвхтэй оролцох боломжийг Чин улсад олгожээ. Ийнхүү 1755-1757 онд Чин улс цэрэг зэвсгийн хүчээр Зүүнгарыг устгаснаас хойш Монголтой харилцах Хятадын харилцаа нь «Ар Монгол» Хятадын харилцаа болжээ.

Тяньцины (1858) болон Бээжингийн (1860) гэрээнүүдийг баталснаар орос-монголын худалдааг хязгаарлалтаас чөлөөлсөн нь хятад-монголын харилцааны шинэ үеийн эхлэл болсон гэж зохиогчид үзжээ. Энэ үеэс эхлэн Оростой худалдааны, дараа нь улс төрийн илүү нягт харилцаа тогтоосноор Чин гүрнээс Монголын хараат байдал аажмаар суларч иржээ. XIX—XX зууны заагт Монголд Цин улсын ноёрхолын эсрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн байн байн өрнөж, монголчуудын үндэсний ухамсар сэргэж ирсэн нь эцсийн эцэст 1911 онд Богд хаант Монгол улсыг байгуулахад хүргэжээ.

БНМАУ-ыг гоминданы Хятад 1945 он хүртэл хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд 1949 онд БНХАУ байгуулагдсаны дараа ч Бээжингийн удирдлага БНМАУ-ын талаарх бодлогодоо их гүрний дээрэнгүй үзлийн байр сууринаас хандаж ирснийг зохиогчид тодорхой баримт дээр нотлон үзүүлжээ. Зөвхөн их гүрний дээрэнгүй үзэл, бодлогоос татгалзах нь монгол-хятадын харилцааг сайжруулах үндэс болно гэдгийг зохиогчид эцэст нь онцлон тэмдэглэжээ.

А. Ходжаев өгүүлэлдээ хятадын Чин гүрэн Зүүнгар болон Зүүн Туркестаныг эзлэн авсан үйл явцыг «дэвшилт» явдал гэж үзэх буюу тэндхийн ард түмнээс манж-хятадын эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг хийсэн тэмцлийг «үймээн самуун» гэж мушгин завхруулсан хятадын түүхчдэд няцаалт өгч түүхэн үнэнийг сэргээн хамгаалжээ. Түүнээс гадна тус эмхтгэлд Хятадаас Кокандын хаант улс, Афганистан, Гималай хавийн улсууд ба Энэтхэг, Зүүн өмнөд Азийн орнууд, Солонгос, Японтой харилцах харилцааны түүхийн жинхэнэ үнэн шинж чанарыг тусган харуулсан өгүүллүүд багтжээ.

XVII—XX зууны үеийн хятад-хөрш орнуудын харилцааны түүхийг өгүүлсэн энэ эмхтгэл Хятадын гадаад бодлогын эзлэн түрэмгийлэх

шинж чанарыг тод харуулж байна. Феодалын хятад төвийн номлолын уламжлалууд хөрш зэргэлдээ орнуудын талаарх Хятадын маоист удирдлагын бодлогод хэрхэн нөлөөлснийг задлан шинжилж БНХАУ-д их гүрний, дээрэнгүй үзлийг залгамжлан авсныг эмхтгэлд нотлон үзүүлснээс гадна БНХАУ-ын орчин үеийн хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхийг тодорхой хэмжээгээр өгүүлснээр хөрш зэргэлдээ орнуудад Бээжингийн удирдлагаас тавьж буй газар нутгийн өнгөлзлөгийн ул үндэсгүй болохыг батлан харуулж байна.

Ц. Батбаяр